

ХОРИХ ЯЛ ЭДЛЭГСДЭЭС ҮЙЛДЭЖ БУЙ ГЭМТ ЯВДЛЫН ӨРНӨЛ, ЧИГ ХАНДЛАГА

CRIMES PRISONERS COMMIT, ITS BACKGROUND AND TRENDS



Н.ГАНТУЛГА ХСИС-ийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургуулийн захирал, хууль зүйн доктор, дэд профессор, хурандаа

GANTULGA N. Director of Institute of Execution of Court Decision, Law Enforcement University, Ph.D, Associate professor, colonel

Товч агуулга: Энэхүү өгүүлээр хорих ял эдлэгсдийн үйлдэж буй гэмт хэрэг, түүний шалтгаан нөхцөлийг судалж, түүнд үндэслэн эрх зүй, эрүүгийн эрх зүйн зохицуулалтыг сайжруулах санал дэвшүүлжээ.

Abstract: This article is focused on crimes prisoners commit, its backgrounds and causes and recommendations based on the study for improvement of regulating law and criminal law.

Оршил: Монгол улсад өрнөж буй шүүх эрх мэдэл, хууль сахиулах салбарын шинэчлэлийн үйл явдалд хорих ял эдлүүлэхтэй холбогдсон харилцаа онцгой анхаарлын төвд байдаг.

Учир нь энэ салбарын харилцаанд оролцогчдын хувьд эрх, эрх чөлөөний үнэ цэнэ илүү ихээр мэдрэгддэг.

“...улсын хар зах, шоронгийн (хорих байгууллагын) амьдралаар тухайн орны бодит нүүр царайг тодорхойлж болно...” гэдэг.

1990-ээд оноос хойш хорих ялд хандах манай төрийн бодлогод зохих өөрчлөлт орж байгаа боловч түүний мөн чанарын гол илэрхийлэл болсон зорилго, гүйцэтгэлийг хангах механизмд төдийлөн шинэчлэл хийгдээгүй.

Өнөөдөр үйлчилж буй Монгол Улсын хууль тогтоомжид хорих ялын зорилгыг тусгайлан тодорхойлоогүй боловч Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 45-р зүйлийн 45.3, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 8-р зүйлийн 8.2 дэх хэсгүүдэд тулгуурлан түүнийг “... иргэн, нийгмийг гэмт халдлагаас хамгаалах, ялтныг цээрлүүлэх, хүмүүжүүлэх, гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх...”-тэй холбож болно.

Иймээс дурьдсан зорилго өнөөдөр хэрхэн хангагдаж байгааг бодитойгоор илэрхийлснээр цаашид төрөөс хорих ялын агуулга, түүний гүйцэтгэлийн бодлогыг оновчтой тодорхойлоход чухал ач холбогдолтой гэж үзлээ.

Сүүлийн жилүүдэд ШШГЕГ-аас хорих ял эдлүүлэх байгууллагын ажлын үр дүнг түүний хуулиархуулалттай хэрхэн уялдуулан үнэлж буйг судлаачийн хувьд бүрэн дэмжиж байдаг.

Мөн цөөнгүй судлаачид энэ чиглэлээр үзэл бодлоо нийтийн хүрээнд илэрхийлж дүгнэлт-санал дэвшүүлснийг харгалзан гадаад орнуудын хорих байгууллага ялын “...гэмт хэргээс урьдчилан сэргийлэх...” зорилгыг хэрхэн хангадаг талаар судлахыг эрмэлзлээ.

Гэвч хорих ял эдлүүлэх салбарын мэдээ материалын ихэнх хаалттай байдагтай уялдан олсон эх сурвалжидаа тулгуурлан ОХУ-ын хорих байгууллагад ямар гэмт хэрэг үйлдэж байгаа, энэ нь манай оронтой харьцуулахад ямар шинжээр нийтлэг, ялгаатайг тодотгохыг зорьлоо.

ОХУ-ын Засан хүмүүжүүлэх байгууллага¹ дах гэмт явдал, чиг хандлага

Ял эдлүүлэх асуудал, тэр дундаас хорих ял эдлэгсдээс үйлдэх гэмт хэргийн шалтгаан нөхцөл, тэмцэх арга зам, урьдчилан сэргийлэх институтыг судлах нь ОХУ-ын хууль зүйн шинжлэх ухааны тулгамдсан, анхаарал татсан чиглэл мөн болохыг

¹ Хорих байгууллагын олон улсын судалгааны төвийн (ICPS) мэдээнээс үзвэл ОХУ-ын 100 мянган хүнд 611 хоригдол ноогддог бөгөөд энэ үзүүлэлтээр дэлхийд 10-рт бичигдсэн байна. ОХУ-д 2014 оны 10-р сарын 01-ний өдрийн байдлаар 671,4 мянган хүн хорих ял эдэлж байгаа ба үүний 1896 хүн бүх наасаараа хорих ялтай. Мэдээллийг www.ru.wikipedia.org/wiki/цахим_сайтаас_авав.

судлаачдынх нь бүтээлээс² харж болно.

Засан хүмүүжүүлэх байгууллага, цагдан хорих газар дахь гэмт явдлын статистик баримтад анализ хийн үзвэл гэмт хэрэг үйлдсэн хорих ял эдлэгсдэд хэрэглэсэн эрүүгийн эрх зүйн нөлөөллийн хамгийн хатуу арга хэмжээ ч ял эдлүүлэх систем дэх энэхүү гэмт явдлын өсөлтийг эрс бууруулах баталгаа болж чадахгүй байна.

Өөрөөр хэлбэл ОХУ-ын хорих байгууллага дахь гэмт явдлын түвшин өндөр хэвээр байна.

2006 он	2007 он	2008 он	2009 он	2010 он	2011 он	2012 он	2013 он
Энэ улсын хорих ял эдлэгсдээс үйлдсэн гэмт хэргийн тоо ³							
1231	1133	964	893	944	799	1280	971

Хорих ял эдлэгсдээс үйлдсэн гэмт хэрэг, зөрчил тодорхой хувь хүмүүст хор хохирол учруулж, хорих байгууллагын⁴ хэвийн үйл ажиллагааг алдагдуулаад зогсохгүй тухайн байгууллагын “эрүүгийн” нөхцөл байдлыг хүндрүүлэн бусад ял эдлэгсдийн ашиг сонирхол, аюулгүй байдал ч нөлөөлж байдаг.

Судалгаанаас үзвэл хорих байгууллага дахь гэмт явдал ял шийтгэгдсэн этгээдээс шүүхийн шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй зөрчилдөх болон ял эдлэх явц дахь олон талт зөрчилдөөн, нийгэм-сэтгэл зүйн үзэгдлүүдтэй нягт холбогдсон өөрийн онцлог зүй тогтолыг агуулдаг.

Нийгмээс тусгаарлагдсан тодорхой дэглэм, нөлөөлөл бүхий амьдралын орчин, ял эдлэгсдийн сэтгэл зүй, аливаа үзэгдэл, үйл явдлыг үнэлэх үзэл, хандлагатай уялдан бий болсон “эрүүгийн ертөнцийн бичигдээгүй хууль-амьдралын хэв маяг⁵” нь үүний гол хөрс суурь мөн.

Статистикийн дээрх баримтаас үзвэл ОХУ-ын хорих байгууллагад үйлдэн бүртгэсэн гэмт хэргийн хамгийн оргил үе сүүлийн 10 жилийн байдлаар авч үзвэл 2006, 2012 онд, харин 2007 оноос энэ тоо аажмаар буурч 2011 онд хамгийн бага үзүүлэлтэд хүрсэнийг харж болно. Мөн статистикийн тоо баримтаас ОХУ-ын Ял эдлүүлэх системийн колони-тосгонд⁶ нийт бүртгэсэн гэмт хэргийн 1/3 -ийг үйлдэж

байна.

Колони-тосгоны гол зориулалт нь хорих ял эдлэгсдийн нийгмийн эерэг харилцаа холбоог улам бататган, хууль журамд захирагдан амьдрах эрмэлзэлийг дэмжихэд чиглэдэг.

Энэ улсын Эрүүгийн ял эдлүүлэх хуулийн 74-р зүйлд зааснаар колони-тосгонд болгоомжгүй гэмт хэрэг болон санаатай хөнгөн, хүндэвтэр гэмт хэрэг үйлдсэн ялтнууд ял эдэлдэг⁷. Иймд судлаачид энэ бүлэгт хамаарах олонхи ялтны зан байдлын онцлогыг:

1. Хорих байгууллагын “бичигдээгүй хууль-хэв маяг”-тай өмнө нь нягт холбогдож байгаагүй.
2. Хорих байгууллагын өвөрмөц орчинд ирээд нэг талаас алба хаагчтай, нөгөө талаас “шоронгийн ертөнцийн” нөлөө бүхий лидерүүдтэй үр ашигтай хэлхээ холбоо тогтоохыг эрмэлздэг.
3. Амьдралын хэв маягын эрс өөрчлөлтөөс “цочрол”-д орж дасан зохицож чадаагүй зарим нь гэмт хэрэг дахин үйлдэх магадлалтай хэмээн тэмдэглэжээ.

Мөн хуулийн 78-р зүйлийн 78.2 дахь хэсгийн “в”, “г”-д заасны дагуу колони-тосгонд жирийн, чанга дэглэмтэй засан хүмүүжүүлэх колониос дэглэм буурсан ялтнууд ял эдэлдэг. Тэдний зан байдлын онцлог нь иргэний нийгэмд гарч амьдралын хэв маягаа өөрчлөх тэмүүлэлтэй, шүүхээс засрал хүмүүжлийг олж байгаа гэж дүгнэсэн явдал юм.

Цөөнгүй судлаачдын тэмдэглэснээр өнөөдөр ОХУ-ын засан хүмүүжүүлэх байгууллагад дэглэмийн агуулга алдагдан суларч, хүмүүжлийн болон гүйцэтгэх ажлын үр дүн багасч улмаар “нэр нөлөө бүхий хорих ял эдлэгсдийн” орон зай нэмэгдэж, хууль бус үйлдлүүд газар авч байгаа⁸ ба үүнийг олон баримтаар нотлохыг эрмэлздэг. Тухайлбал:

ОХУ-ын Ял эдлүүлэх Холбооны Албаны статистик мэдээ							
2006 он	2007 он	2008 он	2009 он	2010 он	2011 он	2012 он	2013 он
Урьдчилан сэргийлэх төрөл бүрийн бүртгэлд авагдсан ялтнуудын тоо /63.78% өсчээ/							
44.372	48.068	53.918	57.000	60.371	63.576	69.673	71,133

ОХУ-ын хууль зүйн сайдын 2006 оны 11-р сарын 20-ны өдрийн 333-р тушаалаар батлагдсан Ял эдлүүлэх байгууллагад хоригдож буй ялтнуудыг эрх зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх зааварт: “... алба хаагчдын бичсэн рапорт тодорхой ялтныг урьдчилан сэргийлэх бүртгэлд авах шийдвэр гаргах үндэслэл болдог...” талаар тусгажээ.

Энэ бүртгэл олон төрөлтэй бөгөөд урьдчилан

ажил хийдэг ялтны ял эдлэх нөхцөлтэй адил” дэглэм гэж харьцангуй байдлаар үзэж болно.

⁷ www.consultant.ru Уголовно-исполнительный кодекс РФ от 08.01.97

⁸ Примак.А.А. О некоторых факторах латентности пенитенциарной преступности //Актуальные проблемы борьбы с преступностью в Сибирском федеральном округе. Красноярск, 2008. с.25

² Костюк М.Ф. Уголовно-правовые и криминологические проблемы с преступностью в исправительных учреждениях. М. 2000г., Хохрин.С.А., Преступность в исправительных учреждениях: динамика и перспективы развития, Омиков.В.И. Пенитенциарная преступность и т.д

³ Отчет о состоянии преступности среди лиц, содержащихся в учреждениях УИС за 2012.г //Пенитенциарная система и общество: опыт взаимодействия. Сборник материалов международной научно-практической конференции, посвященной 135-летию уголовно-исполнительной системы и 105-летию криминологической службы РФ 15-16 мая 2014.г., Пермь 2014.г

⁴ Засан хүмүүжүүлэх колони, цагдан хорих газар, гяндан Орос хэлнээ “криминальная субкультура”

⁶ Монгол улсад ийм дэглэмтэй хорих анги байхгүй бөгөөд харин манай чанга, онцгой дэглэмтэй хорих ангийн гадна бүсэд байрлан “шууд харуул хамгаалалтгүй” үйлчилгээний

сэргийлэх нөлөөлөл, зохион байгуулах арга хэмжээний онцлогтой уялдан ял эдлүүлэх байгууллагын тодорхой нэгжийн алба хаагчдын анхаарлын төвд байдаг. Тухайлбал:

д/д	Урьдчилан сэргийлэх бүртгэлийн төрөл	Анхаарлаа илүү хандуулах шаардлагатай хорих байгууллагын алба хаагч
1	Оргохоор бэлтгэж байгаа болон өмнө нь оргож байсан, хар тамхи, мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх хүчтэй эм, бэлдмэл хэрэглэх, борлуулах, олж авах сонирхолтой ялтнуудын бүртгэл	Гүйцэтгэх албаны алба хаагчид
2	Ял эдлүүлэх байгууллагын захиргааны шаардлагыг эсэргүүцэх, хэвийн үйл ажиллагааг алдагдуулахад чиглэсэн үйлдлийг тогтмол дэмжин зохион байгуулах, нийтийг хамарсан эмх замбараагүй байдалд ялтнуудыг турхирах, уриалах, бусдыг дарамтлах, зохион байгуулалттай гэмт бүлэглэлийг бий болгох, “эрүүгийн ертөнцийн хууль, дүрэм”-ийг дэлгэрүүлдэг ялтнуудын бүртгэл	Аюулгүй байдлын алба хаагчид
3	Согтууруулах ундаанаас хамааралтай, байнга хэрэглэх сонирхолтой, шүүхээс эмчилгээнд хамрагдахаар тооцогдсон, бусад этгээдүүдтэй тооцоо хийх, хавчин гадуурхах, алба хаагчдад халдах магадлалтай ялтнуудын бүртгэл	Аюулгүй байдлын албаны алба хаагчид
4	Мөрийтэй тоглоом зохион байгуулах, түүнд идэвхтэй оролцогч болон гомосексуалист /лесби/ хандлагатай ялтнуудын бүртгэл	Хүмүүжлийн албаны алба хаагчид
5	Сэтгэцийн өөрчлөлттэй улмаас өөртөө болон бусдад аюул учруулж болзошгүй ялтнуудын бүртгэл	Эмнэлгийн алба хаагчид

Мөн ОХУ-ын судлаачид хорих байгууллагын эрүүгийн нөхцөл хүндэрсэн, урьдчилан сэргийлэх бүртгэлд авагдсан ялтны тоо өсч буй үед эсрэгээр ялтны үйлдэн бүртгэлд авагдсан гэмт хэргийн тоо буурч байгааг онцгойлоод энэ нь зарим талаар ял эдлүүлэх байгууллагын ажлын үр дүнг тооцдог үзүүлэлттэй холбоотой гэжээ.

Өөрөөр хэлбэл хэрэг зөрчил их гарч, бүртгэлд авагдвал удирдах байгууллагын зүгээс тухайн байгууллагыг ялтныг хүмүүжүүлэх, нийгэмшүүлэх үүргээ хангалтгүй биелүүлсэн, урьдчилан сэргийлэх арга хэмжээг шаардлагын түвшинд зохион байгуулж чадаагүй хэмээн буруутгадаг.

Энэ нь хорих байгууллагад үйлдсэн зарим гэмт хэрэг, зөрчлийг, ялангуяа бага хохиролтой, хөнгөн гэмт хэргийг (харилцан зодоон, тарчлаах, эрийг эмлэх, жижгээр танхайрах зэрэг⁹) бүртгэлд авалгүй “өөрсдийн аргаар” шийдвэрлэдэг хэвшилд хүргэн улмаар “зохиомлоор” хорих байгууллагын нуугдмал гэмт хэргийн түвшинг нэмэгдүүлдэг¹⁰.

Нөгөө талаас зарим судлаачид ОХУ-ын Ял эдлүүлэх Холбооны Албаны албан ёсны тоо баримтад тулгуурлан сүүлийн жилүүдэд эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах явдал багасаж байгаа үзүүлэлтийг тэмдэглээд үүнд засан хүмүүжүүлэх байгууллагад ял эдлэгсдийн тоо буурсан, мөн ял эдлүүлэх байгууллагын алба хаагчдын тоо багассан

байдал нөлөөлсөн гэжээ.

Он	2006	2007	2008	2009	2010	2011	2012
Эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзсан тоо	11,100	11,338	10,640	8,607	8,833	8,464	7,494

ОХУ-ын Засан хүмүүжүүлэх байгууллагад ял эдлэгсдээс үйлдсэн гэмт хэргийг энэ орны Эрүүгийн хуулийн тусгай ангийн бүтцийн байдлаар нь авч үзвэл:

- а/ Бусдын амь нас, эрүүл мэндийн эсрэг чиглэсэн
- б/ Өмчлөх эрхийн эсрэг чиглэсэн
- в/ Нийгмийн аюулгүй байдал, дэг журмын эсрэг чиглэсэн
- г/ Хүн амын эрүүл мэнд, нийгмийн ёс суртахууны эсрэг чиглэсэн
- д/ Шүүн таслах ажиллагааны эсрэг чиглэсэн
- е/ Захиргааны журмын эсрэг чиглэсэн гэмт хэргүүд голлох хувийг эзэлж байна.

⁹ Энэ гэмт хэргүүд нь зарим газарт хорих байгууллагын жирийн үзэгдэл болон тооцогдож хэвшсэн талаар мөн дурьджээ.

¹⁰ Ишигеев В.С. Наказание и предупреждение преступлений в местах лишения свободы: Монография. Хабаровск. 2003.

д/д	Зүйл анги	он							
		2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013
1	Нийгмээс тусгаарлах явдлыг ханган хэрэгжүүлж буй байгууллагын хэвийн үйл ажиллагааг алдагдуулах -ЭХ-ийн 321-р зүйл	211	195	183	191	165	159	145	195
2	Бусдыг барьцаанд авах - ЭХ-ийн 206 зүйл	1	4	3	2	0	1	0	0
3	Бусдыг алах - ЭХ-ийн 105-р зүйл	18	17	17	23	16	16	25	15
4	Бусдыг алахаар завдах (бусдын амь насыг хөнөөхийг) - ЭХ-ийн 30-р зүйл - ЭХ-ийн 105-р зүйл	5	5	7	4	3	5	3	4
5	Сэтгэл санаа нь хүчтэй цочрон давчидсан үедээ бусдыг алах -ЭХ 107-р зүйл	5	5	2	1	2	0	0	0
6	Аргагүй хамгаалалтын хэр хэмжээг хэтрүүлэн бусдыг алах - ЭХ-ийн 108-р зүйл	5	2	3	2	1	0	2	1
7	Болгоомжгүйгээр бусдыг үхэлд хүргэх -ЭХ-ийн 109-р зүйл	8	2	8	3	2	8	5	4
8	Бусдын эрүүл мэндэд хүнд гэмтэл санаатай учруулснаас хохирогчийн амь насыг хохироох -ЭХ-ийн 111-р зүйл 4-р хэсэг	22	24	22	23	24	18	22	18
9	Бусдын эрүүл мэндэд хүнд гэмтэл санаатай учруулах -ЭХ-ийн 111-р зүйл 1-3 хэсэг	32	18	23	22	24	26	34	31
10	Бусдын эрүүл мэндэд хүндэвтэр гэмтэл санаатай учруулах -ЭХ-ийн 112-р зүйл	42	31	43	43	37	26	29	24
11	Бусдын эрүүл мэндэд хүнд эсвэл хүндэвтэр гэмтэл санаатай учруулах -ЭХ-ийн 113-р зүйл	1	6	4	4	2	1	0	0
12	Аргагүй хамгаалалтын хэр хэмжээг хэтрүүлэн бусдын эрүүл мэндэд хүнд эсхүл хүндэвтэр гэмтэл учруулах -ЭХ-ийн 114-р зүйл	8	5	6	7	3	2	1	2
13	Бусдын эрүүл мэндэд болгоомжгүйгээр хүнд эсхүл хүндэвтэр гэмтэл учруулах -ЭХ-ийн 118-р зүйл	2	4	5	6	6	3	7	4
14	Хорих болон баривчлах, цагдан хорих байгууллагаас оргон зугтах -ЭХ-ийн 313-р зүйл	329	296	172	146	199	187	175	143
15	Хорих ял эдлэхээс зайлсхийх -ЭХ-ийн 314-р зүйл	110	174	48	59	28	30	26	15
16	Нийтийг хамарсан эмх замбараагүй байдал бий болгох /ЭХ-ийн 212-р зүйл/, танхайрах /ЭХ-ийн 213-р зүйл/	3	3	1	1	0	0	1	0
17	Ял дэлүүлэх байгууллагын объектод хулгай хийх -ЭХ-ийн 153-р зүйл		41	25	25	16	16	20	17
18	Мансууруулах бодис олж авах, борлуулах -ЭХ-ийн 228-р зүйл	242	247	281	281	311	239	285	268
19	Бусад гэмт хэрэг		202	181	186	182	151	180	182

Мөн энэ статистик баримтад тулгуурлан

ОХУ-ын хорих байгууллагад 2000 оноос ял эдлэгсдийн үйлдсэн гэмт хэргийн бүтцэд томоохон өөрчлөлт гарсныг харж болно. Учир нь хар тамхи, мансууруулах, сэтгэцэд хүчтэй нөлөөлөх бодис, эм бэлдмэл, тэдгээртэй адилтгах зүйлсийг хууль бусаар олж авах, хадгалах, тээвэрлэх, бэлтгэх, боловсруулахтай холбогдсон гэмт хэрэг ихээр үйлдэгдэх болсон.

Бусдын амь нас, эрүүл мэндийн эсрэг чиглэсэн гэмт хэрэг, тэр дотроос хүн амины гэмт хэрэг эрс буурсан.

Ялтнаас хорих байгууллагын эд хөрөнгийг хулгайлах (153-р зүйлд заасан) гэмт хэрэг үйлдэх болсон¹¹.

ДҮГНЭЛТ, САНАЛ

Илтгэлдээ тулгуурлан сэдвийн агуулгын хүрээнд дараах дүгнэлт, саналыг дэвшүүлж байна.

Манай орны хорих ангиудын ажлыг дүгнэх үзүүлэлт, ялтнаас үйлдсэн гэмт хэрэг, зөрчлийн статистик мэдээ баримтын агуулга, үзүүлэлтэд шинжлэх ухааны анализ хийж шаардлагатай өөрчлөлтүүдийг даруй оруулах. Жишээ нь: ШШГЕГ-ын Тогтоол гүйцэтгэх газраас гаргаж буй бүртгэл-судалгааны маягтаас ялтны үйлдсэн гэмт хэрэг, зөрчлийг зарим тохиолдолд ялгах боломжгүй байна. Энэ нь юуны өмнө бусдын бие махбодид гэмтэл учруулах, алба хаагчийн хууль ёсны шаардлагыг эсэргүүцэх гэсэн үзүүлэлттэй холбоотой.

Хорих ял эдлэгсдээс үйлдэж буй гэмт хэргийн эрүүгийн эрх зүйн шинж, хөдөлгөөнийг судлах нь тэдгээрийг урьдчилан сэргийлэх үр дүнтэй ажил-арга хэмжээг төлөвлөн зохион байгуулах боломжийг нэмэгдүүлнэ гэдгийг иш үндэс болгон төрөл бүрийн “бодлогын судалгааны ажлууд”-ыг явуулж үр дүнг хэлэлцэн эрх зүй, зохион байгуулалтын шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх ёстой.

Пенитенциар гэмт явдал-криминологи судалгаанд онцгойлон ач холбогдол өгч хорих байгууллагад үйлдэгдэх гэмт хэрэг, зөрчлийн “урьдчилсан төлөв-прогноз¹²”-ыг 1, 3 жил болон бусад шаардлагатай хугацаагаар гарган хөтөлбөр-төлөвлөгөө боловсруулан авч хэрэгжүүлэх арга хэмжээ, ажиллах хүн, хүч, зарцуулах хөрөнгө зэргийг тооцон “бодит ажил” болгон хэвших шаардлагатай байна.

Эцэст нь тэмдэглэхэд илтгэлд дурьдсан зүйлс нь ОХУ-ын Засан хүмүүжүүлэх байгууллагын нөхцөл байдалд өгсөн судлаачийн “субъектив” шинжтэй хэсэгчилсэн мэдээлэл болохыг анхаарна уу.

¹¹ Зарим судлаачдын тэмдэглэснээр энэ төрлийн гэмт хэрэг үйлдэгдэж байсан тоо баримт албан ёсны статистикт өмнө нь тусгагдаггүй байжээ.

¹² Гэмт хэрэг, зөрчлийн төрөл, тоо, цаг хугацаа, газар зэргийг